



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Чандмань илч ХХК-ийн
2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОГОВЬ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гулам,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.08.15 № 1-6/395

танай _____ -ны № _____ -т

ЧАНДМАНЬ ИЛЧ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭБЯЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань илч ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Чандмань илч ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

МУЗГ, Азийн хөгжлийн банкны хооронд 2002 онд "Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн хоёрдугаар үе шатны төсөл" МОН-1907-ийн хүрээнд 3,152.9 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний хөрөнгийн зээлийг Дорноговь аймгийн ЗДТГ-тай СЭЗЯ 2003 оны 12 дугаар сард байгуулсан байна. Уг зээлийг аймгийн ЗДТГ нь Чандмань илч ХХК-д жилийн 4.5 хувийн хүүтэй, хүүгийн төлбөрийг хагас жил тутамд, үндсэн өрийн төлбөрийг 2010 оны сүүлийн хагас жилээс эхлэн хагас жил тутамд нийт 18 жилийн турш төлөхөөр дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулсан.

Тайлант онд компанийн санхүү бүртгэлд тус зээлийн үлдэгдэл 1,918.5 сая төгрөг байгаа ба 946.3 сая төгрөгийн зээлийн төлбөрийг аймгийн ЗДТГ-аас Сангийн яаманд төлсөн байна.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус компанийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

ТУЗ-н 2022 оны тогтоолоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 10,113.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 11,920.3 сая төгрөгөөр, 1,806.7

010020001

сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 250.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 10,887.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 12,479.5 сая төгрөгийн зардал гарган, 1,592.0 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Илрүүлэлтээр тус компани нийт 5 харилцагчаас 12.4 сая төгрөгийн түрээсийн орлого олсноос 3 харилцагчийн гэрээг орон нутгийн өмчийн газраар хянуулаагүй, гэрээ байгуулаагүй, 2 харилцагчийн гэрээний хугацааны дууссан, орлогыг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах." заалтыг зөрчин 1.0 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан байна.

Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 28,673.9 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 264.1 сая төгрөгийн 7 тендерийн мэдээлэл, 21,057.0 сая төгрөгийн 472 гүйлгээ, 142.4 сая төгрөгийн 95 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн 2,298.7 сая төгрөгийн 7 тендерийн мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 870.6 сая төгрөгийн орлогын 85 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,221.5 сая төгрөгийн зарлагын 18 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 299.8 сая төгрөгийн 29 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл "Хуулийн үйлчлэх хүрээ"-ийн 3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, тасалбар болголт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Худалдан авалтын төлөвлөгөөг бодитой, үндэслэлтэй батлуулаагүй, ТБОНӨБАҮХА тухай хуулийг мөрдөж ажиллаагүй, батлагдсан худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй сэлбэг, материал, бараа, ажил үйлчилгээг 24 компани, 13 иргэнтэй 5,539.6 сая төгрөгийн шууд худалдан авалтыг хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 6-1/6076 тоотой хүргүүлсэн "Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхэд анхаарах асуудлын талаарх зөвлөмж" 1-д "..... аль тохирох заалтын дагуу тендер шалгаруулалт зарласан байхыг шаардана" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлант онд байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйлс авч, шагнал урамшуулал олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн "15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" "15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус компанийн НББ-д ашиглагдаж байгаа "Виница" программ нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн

программд тавигдах шаардлага хангаагүй, мэдээллийг алдаатай илэрхийлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 47 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ыг хангаагүй байна.

Шинээр орлогод авсан зарим хөрөнгийн ашиглалтын хугацаа нь НБББББ-т тусгаснаас зөрүүтэйгээр бүртгэсэн, дансны авлагыг санхүүгийн тайланд илэрхийлэхдээ төлөгдөх боломжтой үнэ буюу цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлнэ, авлагын цэвэр боломжит үнэ цэнэ нь дансны авлагын нийт дүнгээс найдваргүй авлагын хасагдуулгын нөөцийг хассантай тэнцүү байна гэж тусгасныг мөрдөөгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт"-ийн "18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Нэг харилцагчтай хийгдсэн 1,689.7 сая төгрөгийн гадаад валютаар бүртгэгдсэн авлагыг цуглуулсан үед 32.4 сая төгрөгийн валютын ханшийн өөрчлөлтийн бодит гарзыг, тайлант хугацааны эцэст 8.4 сая төгрөгийн ханшийн өөрчлөлтийн бодит бус ашгийг бүртгээгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

НИК ХХК-Дорноговь салбартай байгуулсан "Шатахууны картын үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний 2.6 дахь "Картаар үйлчлэгч нь карт эзэмшигчид, картаар үйлчлэгчийн мөрдөж буй үнийн 3%-н хөнгөлөлтийг гэрээнд заасны дагуу үзүүлнэ" гэсэн заалтаар хөнгөлөлтийг эдэлдэг бөгөөд уг хөнгөлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, зарцуулалтыг нь тайлагнаагүй байна. Энэ нь НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Чандмань илч ХХК нь 2022 онд 14 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэлийг 92 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	537,241,870.44	591,983,097.44
1.1.2	Дансны авлага	2,192,614,113.52	837,198,431.55
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	469,310.16	0.00
1.1.4	Бусад авлага	41,507,169.93	156,782,514.86
1.1.6	Бараа материал	1,034,906,023.86	1,722,374,486.61
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	539,776,999.31	4,811,584,684.24
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,346,515,487.22	8,119,923,214.70
1.2.1	Үндсэн хөрөнгө	25,434,989,445.07	27,648,985,558.27
1.2.2	Биет бус хөрөнгө	2,687,846,138.15	2,673,655,420.82
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	28,122,835,583.22	30,322,640,979.09
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	32,469,351,070.44	38,442,564,193.79
2.1.1.1	Дансны өглөг	369,421,302.85	629,267,414.53
2.1.1.3	Татварын өр	427,340,115.35	176,489,647.84
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.00	222,938.68
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	999,999,999.57	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	18,741,357.25	5,821,414,774.25
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,815,502,775.02	6,627,394,775.30
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,918,465,293.49	1,918,465,293.49
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	11,540,396,250.90	14,284,627,217.63
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	13,458,861,544.39	16,203,092,511.12
2.2	Өр төлбөрийн нийт дүн	15,274,364,319.41	22,830,487,286.42
2.3.1	Өмч: -төрийн	15,459,856,685.46	15,459,856,685.46
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,731,578,024.44	7,388,629,707.44
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	512,609,701.20	521,700,701.20
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-6,509,057,660.07	-7,758,110,186.73
2.3.9.1	Тайлант үеийн ашиг	-61,848,522.68	-1,592,001,243.66
2.3.9.2	Хуримтлагдсан ашиг	-6,447,209,137.39	-6,166,108,943.07
2.3.11	Эздийн өмчийн нийт дүн	17,194,986,751.03	15,612,076,907.37
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	32,469,351,070.44	38,442,564,193.79

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	12,451,387,711.83	10,283,871,765.78
2	Борлуулалтын өртөг	12,144,382,523.69	11,269,534,972.14
3	Нийт ашиг (алдагдал)	307,005,188.14	-985,663,206.36
4	Түрээсийн орлого	13,844,727.26	12,435,272.71
8.1	Орлогын дүн	13,844,727.26	12,435,272.71
9	Борлуулалт, маркетингийн зардал	147,329,412.31	163,775,864.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	689,132,417.07	775,614,670.90
12	Бусад зардал	139,666,461.51	270,558,288.32
12.1	Зардлын дүн	976,128,290.89	1,209,948,823.77
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	772,981.19	2,261,834.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	-169,928,807.85
17	Бусад ашиг (алдагдал)	521,763,962.04	758,842,487.61
17.1	Олз гарзын дүн	522,536,943.23	591,175,513.76
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-132,741,432.26	-1,592,001,243.66
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-132,741,432.26	-1,592,001,243.66
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-132,741,432.26	-1,592,001,243.66

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,459,856,685.46	7,731,578,024.44	512,609,701.20	- 6,370,238,264.75	17,333,806,146.35
2	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-6,077,963.06	-6,077,963.06
3	Залруулсан үлдэгдэл	15,459,856,685.46	7,731,578,024.44	512,609,701.20	- 6,376,316,227.81	17,327,728,183.29
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-132,741,432.26	-132,741,432.26
9	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,459,856,685.46	7,731,578,024.44	512,609,701.20	- 6,509,057,660.07	17,194,986,751.03
10	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	342,948,717.00	342,948,717.00
11	Залруулсан үлдэгдэл	15,459,856,685.46	7,731,578,024.44	512,609,701.20	- 6,166,108,943.07	17,537,935,468.03
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	- 1,592,001,243.66	-1,592,001,243.66
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	9,091,000.00	-	9,091,000.00
16	Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-342,948,317.00	-	-	-342,948,317.00
17	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,459,856,685.46	7,388,629,707.44	521,700,701.20	- 7,758,110,186.73	15,612,076,907.37

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,046,472,809.78	20,286,774,982.73
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11,810,766,994.38	18,711,620,498.73
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,365,288.00	242,622.00
1.1.5	Татаас, санхүүжилтын орлого	1,212,320,000.00	1,553,131,938.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	21,020,527.40	21,779,924.00
1.2	Мөнгөн зарлага (-)	13,081,408,976.99	19,223,234,852.05
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,965,357,894.11	5,143,542,918.72
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	966,017,941.42	1,123,882,177.71
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	5,145,661,173.11	7,297,745,055.72
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,026,754,559.57	1,335,683,625.07
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	668,237,115.00	1,382,320,021.20
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	31,950,958.44	6,605,424.67
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	829,235,684.20	1,127,819,552.61
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	12,229,373.29	11,534,608.86
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,435,964,277.85	1,794,101,467.49
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-34,936,167.21	1,063,540,130.68
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	155,691,150.00	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	48,599,900.00	0.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	107,091,250.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-155,691,150.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,232,349,352.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,232,349,352.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	903,863,435.56	1,008,798,903.68
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	903,863,435.56	1,008,798,903.68
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	328,485,916.44	-1,008,798,903.68
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	137,858,599.23	54,741,227.00
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	399,383,271.21	537,241,870.44
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	537,241,870.44	591,983,097.44

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт: Дулаан үйлдвэрлэлт	Гкал	58,000.00	60,893.00	-2,893.00	-4.99%
	Цэвэр ус олборлолт	м3	320,000.00	322,680.00	-2,680.00	-0.84%
	Бохир ус татан зайлуулалт	м3	256,000.00	288,860.00	-32,860.00	-12.84%
2	Нийт орлого	төгрөг	10,113,549,500.00	10,887,481,600.00	-773,932,100.00	-7.65%
	Үүнээс: Цэвэр борлуулалт	төгрөг	9,915,549,500.00	9,972,259,800.00	-56,710,300.00	-0.57%
	Бусад орлого /алданги торгуулийн засвар үйлчилгээний орлогууд/	төгрөг	198,000,000.00	915,221,800.00	-717,221,800.00	-362.23%
3	Нийт зардал	төгрөг	11,920,289,500.00	12,479,483,800.00	-559,194,300.00	-4.69%
	Үүнээс: Удирдлагын зардал	төгрөг	940,000,000.00	938,251,000.00	1,749,000.00	0.19%
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	төгрөг	-1,806,740,100.00	-1,592,002,100.00	-214,738,000.00	11.89%
5	Улсын төсвийн татаас	төгрөг	0.00	0.00	0.00	
6	Цэвэр ашиг, алдагдал	төгрөг	-1,806,740,100.00	-1,592,002,100.00	-214,738,000.00	11.89%
7	<i>Төсвийн төлбөрт нийт дүн</i>	төгрөг				
8	Төрийн өмчийн ногдол ашигт	төгрөг		0.00		
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	385	317	68.00	17.66%
10	Нийт цалингийн сан	төгрөг	5,232,590,000.00	4,545,449,200.00	687,140,800.00	13.13%
11	Нэг ажиллагчийн дундаж цалин	төгрөг		1,038,383.00		
12	Нэгж бүтээгдэхүүний өртөг-Дулаан	төг/Гкал		105,684.10		
	Нэгж бүтээгдэхүүний өртөг-Цэвэр ус	төг/м.куб		3,389.00		
	Нэгж бүтээгдэхүүний өртөг-Бохир ус	төг/м.куб		1,877.00		
13	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг		1.25		
14	Хөрөнгө оруулалт	төгрөг	250,000,000.00	251,000,000.00	-1,000,000.00	-0.40%
15	Нийт авлага	төгрөг		992,450,198.72		
16	Нийт өглөг	төгрөг		22,828,956,537.23		
	Үүнээс: Богино хугацаат	төгрөг		6,681,447,480.61		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 256.4 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 256.4 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Хойшлогдсон орлогоор бүртгэх 55.6 сая төгрөгийн ажил гүйлгээг урьдчилж орсон орлогоор бүртгэснийг;
2. Харилцагчидтай үүссэн 199.3 сая төгрөгийн тооцоог авлага болон өглөгийн дансанд бүртгэснээс бодит үлдэгдэл 199.3 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн, мөн 1.5 сая төгрөгийн хасах дүнтэй өр төлбөрийг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 9 зөрчил² илэрснээс, 13.4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 3 албан шаардлага, 4 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Тус компани нийт 5 харилцагчаас 12.4 сая төгрөгийн түрээсийн орлого олсноос 3 харилцагчийн гэрээг орон нутгийн өмчийн газраар хянуулаагүй, гэрээ байгуулаагүй, 2 харилцагчийн гэрээний хугацааны дууссан, орлогыг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлээгүй байх тул 12.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.” заалтыг зөрчин 1.0 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсанд төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 28,673.9 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 264.1 сая төгрөгийн 7 тендерийн мэдээлэл, 21,057.0 сая төгрөгийн 472 гүйлгээ, 142.4 сая төгрөгийн 95 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн 2,298.7 сая төгрөгийн 7 тендерийн мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 870.6 сая төгрөгийн орлогын 85 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,221.5 сая төгрөгийн зарлагын 18 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 299.8 сая төгрөгийн 29 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл “Хуулийн үйлчлэх хүрээ”-ийн 3.1.Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх, тасалбар болголт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Худалдан авалтын төлөвлөгөөг бодитой, үндэслэлтэй батлуулаагүй, ТБОНӨБАҮХА тухай хуулийг мөрдөж ажиллаагүй, батлагдсан худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй сэлбэг, материал, бараа, ажил үйлчилгээг 24 компани, 13 иргэнтэй 5,539.6 сая төгрөгийн шууд худалдан авалтыг хийсэн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 6-1/6076 тоотой хүргүүлсэн "Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхэд анхаарах асуудлын талаарх зөвлөмж" 1-д "... аль тохирох заалтын дагуу тендер шалгаруулалт зарласан байхыг шаардана" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тайлант онд байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйлс, шагнал урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн "15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;", "15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус компанийн НББ-д ашиглагдаж байгаа "Виница" программ нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага хангаагүй, журнал, мэдээллийг алдаатай илэрхийлж байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 47 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ыг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: НББ-ийн бодлогод нийцсэн, найдвартай ажиллагааг хангаж чадах Сангийн яамны зөвшөөрөлтэй, санхүүгийн программ ашиглах

2. НБББББ-ийн мөрдөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шинээр орлогод авсан зарим ашиглалтын хугацаа нь НБББББ-т тусгаснаас зөрүүтэйгээр бүртгэсэн, дансны авлагыг санхүүгийн тайланд илэрхийлэхдээ төлөгдөх боломжтой үнэ буюу цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлнэ, авлагын цэвэр боломжит үнэ цэнэ нь дансны авлагын нийт дүнгээс найдваргүй авлагын хасагдуулгын нөөцийг хассантай тэнцүү байна гэж тусгасныг мөрдөөгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт"-ийн "18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх НБББББ-ийг мөрдөж ажиллах

3. Гадаад төлбөр тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэг харилцагчтай хийгдсэн 1,689.7 сая төгрөгийн гадаад валютаар бүртгэгдсэн авлагыг цуглуулсан үед 32.4 сая төгрөгийн валютын ханшийн өөрчлөлтийн бодит гарзыг, тайлант хугацааны эцэст 8.4 сая төгрөгийн ханшийн өөрчлөлтийн бодит бус ашгийг бүртгээгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажиллах

4. Шатахууны тооцоо, тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: НИК ХХК-Дорноговь салбартай байгуулсан “Шатахууны картын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний 2.6 дахь “Картаар үйлчлэгч нь карт эзэмшигчид, картаар үйлчлэгчийн мөрдөж буй үнийн 3%-н хөнгөлөлтийг гэрээнд заасны дагуу үзүүлнэ” гэсэн заалтаар хөнгөлөлтийг эдэлдэг бөгөөд уг хөнгөлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, зарцуулалтыг нь тайлагнаагүй байна.

НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны хөнгөлөлтийг нягтлан бодох бүртгэлд тусгах, шатахуун зарцуулалт хийгдсэн тухай бүр бүртгэл хөтлөх, цаашид алдааг давтан гаргахгүй байх

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтүүдийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хойшлогдсон орлогоор бүртгэх 55.6 сая төгрөгийн ажил гүйлгээг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн.	1	55,583.4			1	55,583.4	1	55,583.4				
Харилцагчидтай үүссэн 199.3 сая төгрөгийн тооцоог авлага болон өглөгийн дансанд бүртгэснээс бодит үлдэгдэл 199.3 сая төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн, мөн 1.5 сая төгрөгийн хасах дүнтэй өр төлбөрийг тус тус залрууллаа.	1	200,855.8			1	200,855.8	1	200,855.8				
Дүн	2	256,439.2			2	256,439.2	2	256,439.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 28,673.9 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 264.1 сая төгрөгийн 7 тендерийн мэдээлэл, 21,057.0 сая төгрөгийн 472 гүйлгээ, 142.4 сая төгрөгийн 95 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн 2,298.7 сая төгрөгийн 7 тендерийн мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 870.6 сая төгрөгийн орлогын 85 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,221.5 сая төгрөгийн зарлагын 18 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 299.8 сая төгрөгийн 29 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1		-	-	1	-		
Дүн	1		-	-	1	-		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Худалдан авалтын төлөвлөгөөг бодитой, үндэслэлтэй батлуулаагүй, ТБОНӨБАҮХА тухай хуулийг мөрдөж ажиллаагүй, батлагдсан худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй сэлбэг, материал, бараа, ажил үйлчилгээг 24 компани, 13 иргэнтэй 5,539.6 сая төгрөгийн шууд худалдан авалтыг хийсэн байна.	1				1								
Тайлант онд байгууллагын хөрөнгийн 29.0 сая төгрөгийг бэлэг дурсгалын зүйлсэд, 33.2 сая төгрөгийг шагнал урамшуулалд зарцуулсан байна.	1				1								
Тус компанийн НББ-д ашиглагдаж байгаа “Виница” программ нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага хангаагүй, мэдээллийг алдаатай илэрхийлсэн байна.	1						1						
Шинээр орлогод авсан зарим ашиглалтын хугацаа нь НБББББ-т тусгаснаас зөрүүтэйгээр бүртгэсэн, “дансны авлагыг санхүүгийн тайланд илэрхийлэхдээ төлөгдөх боломжтой үнэ буюу цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлнэ, авлагын цэвэр боломжит үнэ цэнэ нь дансны авлагын нийт дүнгээс найдваргүй авлагын хасагдуулгын нөөцийг хассантай тэнцүү байна” гэж тусгасныг мөрдөөгүй байна.	1						1						
Нэг харилцагчтай хийгдсэн 1,689.7 сая төгрөгийн гадаад валютаар бүртгэгдсэн авлагыг цуглуулсан үед 32.4 сая төгрөгийн валютын ханшийн өөрчлөлтийн бодит гарзыг, тайлант хугацааны	1	40,855.6					1	40,855.6					

эцэст 8.4 сая төгрөгийн ханшийн өөрчлөлтийн бодит бус ашгийг бүртгээгүй байна.												
НИК ХХК-Дорноговь салбартай байгуулсан “Шатахууны картын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний 2.6 дахь “Картаар үйлчлэгч нь карт эзэмшигчид, картаар үйлчлэгчийн мөрдөж буй үнийн 3%-н хөнгөлөлтийг гэрээнд заасны дагуу үзүүлнэ” гэсэн заалтаар хөнгөлөлтийг эдэлдэг бөгөөд уг хөнгөлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй, зарцуулалтыг нь тайлагнаагүй байна.	1						1					
Тус компани нийт 5 харилцагчаас 12.4 сая төгрөгийн түрээсийн орлого олсноос 3 харилцагчийн гэрээг орон нутгийн өмчийн газраар хянуулаагүй, гэрээ байгуулаагүй, 2 харилцагчийн гэрээний хугацааны дууссан, орлогыг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлээгүй.	1	12,435.3	1	12,435.3								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.” заалтыг зөрчин 1.0 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан.	1	1,020.0	1	1,020.0								
Дүн	7	54,310.9	2	13,455.3	2		4	40,855.6				